



"ЛэндМН ББСБ" ХК

2021 оны  
III улирлын санхүү,  
үйл ажиллагааны  
тайлан



[www.fb.com/LendMN](https://www.fb.com/LendMN)

[www.lend.mn](https://www.lend.mn)



Асаа. Асуудлаа шийд



# Агуулга

→	Зээлийн үйл ажиллагаа	06
→	Бизнесийн үйл ажиллагаа	09
→	Харилцагчийн үйл ажиллагаа	18
→	Санхүүгийн үйл ажиллагаа	20
→	Эрсдэлийн удирдлага	23
→	Компанийн засаглал	26



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

# “ЛэндМН зээлийн бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэхээр ажиллаж байна.”

Сайн байна уу?

“ЛэндМН ББСБ” ХК-ийн эрхэм хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, бизнесийн түнш, хамтрагч байгууллагууд болон бидэнд үргэлж итгэл хүлээлгэн үргэлж дэмжин ажилладаг нийт харилцагчид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

Миний бие нь 2020 оноос ЛэндМН компанид дэд захирлаар ажиллаж байгаад 2021 оны 07 сарын 30-ны өдрийн №21/30 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр Гүйцэтгэх захирлаар томилогдоод байна. ЛэндМН нь Монголын анхны стартап компаниудын нэг бөгөөд анхны финтек компани юм. Манай компани нь үйл ажиллагаагаа

явуулаад тав дахь жил нь энэ жил тохиож байгаа бөгөөд байгууллагын хувьд хөгжлийнхөө дараагийн үе рүү орж байна.

Дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлчилгээ бүтээхийн тулд байгууллага өөрөө хөгжих, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх тийм чадвартай байх нь чухал юм. ЛэндМН-д ажиллаж эхлэхдээ байгууллагын цаашдын хөгжил, компанийн үнэ цэнийг өсгөх урт хугацаанд тогтвортой хөгжихөд шаардлагатай шийдлүүдийг олох, байгууллагын соёлыг бүрдүүлэх, бэхжүүлэх зорилгоор ажлуудаа эхэлсэн.

Мөн (КОВИД-19) цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлтэй энэ үед эрсдэлийн менежментийн

бодлогыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчийг нэн тэргүүнд тавьж оновчтой шийдвэрийг цаг тухай бүр гаргах дээр онцгой анхаарч ажилласаар байна. Учир нь бид санхүүгийн компани учраас эрсдэлийн менежмент дээр түлхүү анхаарсаар байна. Өөрөөр хэлбэл аливаа эрсдэлд бэлэн байх, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах, харилцагчдадаа уян хатан, боломжит нөхцөлийг санал болгох зэрэг шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг тогтвортой, найдвартай явуулахад анхаарч байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ийн нөлөөлөл нь компанийг хурдтай ажиллах, шийдвэр гаргах, хариу үзүүлэх шаардлагатайг бидэнд ойлгуулсан. ЛэндМН-ийн хувьд энэ жил (КОВИД-19)-өөс шалтгаалсан эдийн засгийн хувьд тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилж байгаа хэдий ч зээлийн төрлөө нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа орон нутаг руу тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах, аппликейшн, системээ шинэчлэх гээд олон олон ажлуудыг төлөвлөн, хийж эхлээд байна. ЛэндМН нь байгуулагдсан цагаас хойш санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нөгөө талаасаа санхүүгийн боловсролыг сайжруулах тал дээр анхаарч ирсэн. Нийт бүртгэлтэй харилцагч 900 мянгад хүрсэн байгаа нь ЛэндМН-ийг хүртээмжтэй ажиллаж буйг илтгэж байна. ЛэндМН нь зах зээлд технологи дээр тулгуурласан санхүүгийн үйлчилгээг анх нэвтрүүлж, түүчээлэн ажиллаж байсан бол одоо СЗХ-д бүртгэлтэй 22 компани финтекийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр компаниуд маань үйлчилгээгээ үзүүлэхэд хэрэглэгчид аль хэдийн аппликейшнээр дамжуулан үйлчилгээ аваад сурсан, харьцангуй бэлтгэгдсэн хэрэглэгчид болжээ гэж харж байна. LendMN аппликейшнээр дамжуулан Улаанбаатар хот төдийгүй алслагдсан орон нутгийн хүмүүс ч санхүүгийн үйлчилгээ авах боломжтой байдаг. Тэгэхээр орон нутгийн харилцагчид маань ч гэсэн шинэлэг бүхнээс хоцрохгүй байна гэсэн үг юм. Аппликейшнээр дамжуулан зээл авах нь нэг талаасаа цаас хэрэглэхгүй байгаль орчинд ээлтэй үйлчилгээ төдийгүй бидний хувьд хамгийн чухал зүйл болох цаг хугацааг давхар хэмнэж байна. Нөгөө талаасаа зайнаас үйлчилгээ авах боломж нь өнөөгийн эрсдэлтэй нөхцөл байдлын хувьд хамгийн том гол хэрэгцээ шаардлагуудын нэг боллоо.

Дэлхий даяар байгаль орчны өөрчлөлтөд анхаарал хандуулж

буй энэ үед ЛэндМН нь ногоон санхүүжилтийг дэмжих, Монгол Улсын хэмжээнд тулгараад буй байгаль орчны хор нөлөөг бууруулахад өөрийн хувь нэмрийг оруулах, энэхүү үйл хэрэгт Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудыг манлайлан ажиллах зорилгоор Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС холбоо)-ны гишүүнээр элсэн орсон. Бид зорилгынхоо хүрээнд компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг байгальд ээлтэй байх зарчмыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Өнгөрөгч 7 дугаар сарын 30-ны өдрийн ЛэндМН-н ТУЗ-ийн хурлаар ЛэндМН компанийн цаашдын бизнес төлөвлөгөөтэй холбоотой томоохон шийдвэр гарсны нэг нь компани маань 1 сая ам.доллар буюу 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг 5 жилийн хугацаатай, 14% хүүтэй хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлж өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэр гарч, Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх зөвшөөрлөө авсан явдал байлаа. Өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээр бид зээлийн үйл ажиллагаагаа улам тэлэх, нөгөөтээгүүр эх үүсвэр татах боломжтой болоод байна.

Бид бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, дэлхийд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, байгууллагаараа хамтдаа өсөн дэвжиж, тасралтгүй хөгжих тал дээр анхааран ажиллаж байгаа билээ. ЛэндМН-ийн үндсэн систем болон аппликейшнийг Анд группийн охин компани хөгжүүлдэг. Энэ жил группийн охин компани болох “Анд Солюшин” компанитай технологи нийлүүлэх болон лицензийн гэрээ үзэглэлээ. Тодруулбал тус гэрээгээр үндсэн систем нийлүүлэх, сайжруулах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх нөхцөлүүдээ шинэчлэн баталсан юм. Тийм ч утгаараа зээлийн үйл ажиллагаагаа тэлэх төлөвлөгөөтэй байгаа. Ингэхийн тулд зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахаар төвлөрч байна. Мөн зээлийн системээ шинэчлэх, аппликейшнээ шинэчлэхээр төлөвлөж байна. Удахгүй хэрэглэгч, харилцагчдадаа шинэ бүтээгдэхүүнээр бэлэг барихаар ажиллаж байгааг дурдахад таатай байна.

Бидэнд үргэлж итгэл хүлээлгэж, дэмжин ажилладаг нийт харилцагчдадаа, хамтран ажилладаг аж ахуйн нэгж, албан байгууллагууд болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа гүнээ талархаж явдгаа энэ дашрамд илэрхийлье.

Ингээд ЛэндМН-ийн нийт харилцагчид, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2021 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Хүндэтгэсэн:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Удвал



01




# Зээлийн үйл ажиллагаа

2021 оны III улиралд гэрээт харилцагчдын тоо өмнөх улирлаас 1.4%-аар өсч, 180.1 мянгад хүрлээ. Мөн энэ улиралд нийт 51.5 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 241.1 мянган зээлийг харилцагчдадаа олгосон нь өмнөх улирлын үнийн дүнгээс даруй 27%-аар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн цэвэр зээлийн багц өмнөх улирлаас 17%-аар тэлж амжилттайгаар энэ улирлыг үдлээ.

## 2021 оны III улирлын үзүүлэлтүүдийг өмнөх тайлант үетэй харьцуулсан байдал


### Гэрээт харилцагчийн тоо

(Өссөн дүнгээр, мянган харилцагч)




### Зээлийн хугацаа сунгасан болон олгосон зээлийн тоо

(мянган зээл)




### Шинээр олгосон болон сунгасан зээлийн дүн

(тэрбум төгрөг)



### Цэвэр зээлийн багц

(тэрбум төгрөг)



■ Олгосон зээл ■ Сунгасан зээл

## Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2021 оны III улиралд чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 6.9% болж буурсан байна. Түүнчлэн энэ улиралд зээлийн эрсдэлийн сангийн зардлыг 100 саяар нэмэгдүүлснээр зээлийн эрсдэлийн сангийн нөөц 2.8 тэрбум төгрөгт хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 124.9%-д хүрсэн байна.

Тэрбум төгрөг	2021.I	2021.II	2021.III
<b>Нийт зээлийн багц</b>	<b>30.6</b>	<b>28.4</b>	<b>33.0</b>
Зээлийн эрсдэлийн сан	(3.0)	(2.7)	(2.8)
<b>Цэвэр зээлийн багц</b>	<b>27.6</b>	<b>25.7</b>	<b>30.2</b>
Хэвийн зээл	27.8	26.0	29.8
Хугацаа хэтэрсэн зээл	0.6	0.4	0.9
Чанаргүй зээл	2.2	2.0	2.3
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	7.3%	7.0%	6.9%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	135.7%	135.3%	124.9%





02



# Бизнесийн үйл ажиллагаа

## “ЛэндМН ББСБ” ХК-ийн толгой компани болох “АНД ГЛОБАЛ” нь 1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг нэмэлтээр “ЛэндМН ББСБ” ХК-д орууллаа

“ЛэндМН ББСБ” ХК нь ТУЗ-ийн хурлын шийдвэрээр АНД группийн толгой компани болох “АНД Глобал” компаниас 1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хоёрдогч өглөгөөр авахаар шийдвэрлэжээ.

Хоёрдогч өглөгөөрх хөрөнгө оруулалт нь 5 жилийн хугацаатай, жилийн 14%-ийн хүүтэй ба хугацааны эцэст хувьцаанд хөрвөх эсэхийг ЛэндМН-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдэх юм. Энэхүү хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төрлийн зээлийн бүтээгдэхүүн гаргахад ашиглахаар төлөвлөж байна.

Ийнхүү хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулалт авч өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх нь ЛэндМН нээлттэй бонд болон итгэлцлээр нэмэлт эх үүсвэр татах боломжийг олгож байгаа болно.

Анд Глобал компани нь Марубени корпораци болон SBI Holdings (хуучнаар Softbank investment), Цахиурын хөндийн Techstars венчур хөрөнгө оруулалтын сангаас Монголын СтартАп компанийн анхны олон улсын Series A шатны хөрөнгө оруулалтыг нийт 15.3 сая ам.доллаароор татан төвлөрүүлсэн ба энэ нь Монголдоо төдийгүй Азидаа томдоо орох Series A шатны хөрөнгө оруулалт боллоо.

Мөн Анд Глобал компани нь Марубени корпораци болон SBI Holdings компаниудтай Ази Номхон далайн бүс нутагт “Open Alliance” буюу нээлттэй хамтын ажиллагааг эхлүүлсэн ба ингэснээр өөрсдийн зохион бүтээсэн технологи болон “Ноу-Хау”-аа Марубени корпораци болон SBI-тай хамтран олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нийлүүлэх ажил нь улам эрчимжиж байгаа болно. Мөн татан төвлөрүүлсэн хөрөнгөөсөө өөрийн охин компани болох ЛэндМН-д нэмэлт хөрөнгө оруулалт хийж байгаа Анд Глобал нь ЛэндМН-ийн II улиралд гаргасан 5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын 100% батлан даалтыг гаргасан билээ.





## **ЛэндМН нь санхүүгийн тайландаа аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагаар Том дөрөвт ордог олон улсын аудитын компанийг дахин сонголоо**

ЛэндМН-ийн нэг зорилго нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц бүтээгдэхүүн үйлчилгээтэй болох зорилготой бөгөөд Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхийн тулд дэлхийн стандартад хүрч ажиллаж байна уу гэдэг нь бидний хувьд чухал. Бид 4 жил дараалан олон улсад нэр хүндтэй Big Four-т багтдаг “Эрнст Энд Янг Монголия Аудит” компаниар аудит хийлгэж байгаа нь санхүүгийн тайлагналдаа олон улсын стандартыг хэрэгжүүлдэг гэдгээ баталж байгаа юм. Нөгөө талаас олон улсын компаниудтай ажиллах нь тэдний ноу хауг судлах боломжийг бүрдүүлдэг.



## ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ

ЛэндМН нь өөрсдийн найдвартай, үнэнч харилцагч нартаа эко автомашины зээл болох байгаль орчинд ээлтэй, хагас цахилгаан мотортой Toyota Aqua, Prius 30, Prius 40, Prius 41 автомашинуудыг хиймэл оюун ухаанд суурилан, харилцагчийн зээлийн скоринг хийж тус бүтээгдэхүүнийг онцгой нөхцөлтэйгөөр санал болгож байна.

LendMN аппликейшнээ татаж эко автомашины зээлийн эрх үүссэн эсэхээ шалгах боломжтой. Эко автомашины зээлийн эрх LendMN-ээр шалгахад нэмэлт материал шаардлагагүй зөвхөн хувийн болон дансны мэдээллээ оруулан “Автомашины зээлийн эрх шалгах” цэс дээр дарахад систем автоматаар хариу мэдэгдэх болно.

#ЭкоХэрэглээндЗориулыя

#ЭкоАвтоМашиныЗээл

#EcoХэрэглээнд  
*Зориулыя*





## Plus үйлчилгээ

Цар тахлын үед хэрэглэгч нартаа зайнаас авах боломжтой хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн болох санхүүгээ зөв удирддаг хүн бүрт зориулсан богино хугацааны “Plus итгэлцлийн”-үйлчилгээг SuperUp аппликейшнд амжилттай нэвтрүүлээ.

1 plus нь 7, 14, 21, 28 хоногийн хугацаатай, хамгийн багадаа 100,000 төгрөг, хамгийн ихдээ 1 сая төгрөг хүртэл итгэлцэл байршуулна. 1 харилцагч нийт 30 Plus болон 30 сая төгрөг хүртэл байршуулах боломжтой юм. Зохицуулагч байгууллагын “Цахим мөнгөний журам”-ын дагуу нэг өдөрт Plus байршуулах дээд хэмжээ нь 3 сая төгрөг байна. 3 сая төгрөгөөс дээш дүнгээр үйлчилгээг ашиглахдаа өөр өөр өдрүүдэд хуваан байршуулахыг зөвлөж байна.

SuperUp аппликейшний “Plus” цэс рүү ороод үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу. Цаашид LendMN аппликейшнд Plus үйлчилгээг нэмж оруулахаар төлөвлөж байна.

#Plus\_бол\_боломж

#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав





## Гадаадаас мөнгөн гуйвуулга хүлээн авах үйлчилгээ

ЛэндМН нь олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Лондонд төвтэй Thunes компанитай хамтран нэвтрүүлээд хэдийнээ 2 жил болжээ. Thunes компани нь дэлхийн 110 гаруй орны 9000 гаруй компанийн төлбөрийн системтэй хамтран ажилладаг.

Хамтын ажиллагааны хүрээнд Western Union болон БНСУ-ын Hanpass төлбөрийн системээр дамжуулан Монгол руу LendMN-ийн хэрэглэгч нарт хамгийн хурднаар, хамгийн бага шимтгэлтэйгээр мөнгөн гуйвуулга хүлээн авах боломжийг олгодог.

Western union нь дэлхийн 200 гаруй улсаас мөнгөн гуйвуулга хийдэг бол Hanpass аппликейшн нь БНСУ-ын бүх банкнуудын данстай холбогддог ба ердөө 5 секундийн дотор хүлээн авах боломжтой.

Хүлээн авагч нь LendMN болон SuperUp аппликейшний хэрэглэгчид байх ба бүртгэлээ баталгаажуулснаар гадаад гуйвуулгаа хялбархан хүлээн авах боломжтой гэсэн үг юм.

Гадаад мөнгөн гуйвуулгаа Лэндийн хэтэвчээрээ хүлээн аваарай.

#Thunes

#ХялбарХэрэглээндЗориулъя

# Монгол орон даяар гэрээ байгуулж эхэллээ

LendMN аппликэйшнээр дамжуулан Улаанбаатар хот төдийгүй орон нутгийн хүмүүс ч санхүүгийн үйлчилгээ авах боломжтой байдаг.

ЛэндМН-ийн зүгээс хөдөө орон нутгийн харилцагчдадаа цахим зээлийн гэрээ байгуулах “Зон Олондоо Зориулья” компани ажлыг зохион байгуулж аймагтаа асуудлаа шийдэх боломжийг олгож ажиллалаа.

Энэхүү ажлын хүрээнд Монгол орон даяар цахим зээлийн гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд 21 аймаг 9 дүүрэгт гэрээгээ байгуулах боломжтой боллоо.

Тэгэхээр орон нутгийн харилцагчид маань ч гэсэн шинэ шинэлэг бүхнээс хоцрохгүйгээр хэрэгцээндээ зориулсан цахим зээлийн үйлчилгээг хэзээ ч хаанаас ч хүртээмжтэйгээр авах боломжийг олгож аймаг тус бүрийн гэрээ байгуулах нотариатуудын мэдээллийг орон нутгийн харилцагчдадаа мэдээллэн ажиллалаа.

Мөн Улаанбаатар хотод байгаа шинээр гэрээ байгуулах боломжтой харилцагчид маань LendMN аппликэйшнээсээ өөрт хамгийн ойрхон нотариатын байршлаа сонгон цахим зээлийн гэрээгээ байгуулах боломж үргэлжилсээр байна.

Харилцагч та LendMN аппликэйшнээ Apple store, Play Store-с татаад БҮРТГЭЛЭЭ БАТАЛГААЖУУЛААД хамгийн их ашигладаг ДАНСНЫ ХУУЛГАА илгээгээд зээлийн шийдвэр гарсан тохиолдолд нэг удаа ГЭРЭЭ БАЙГУУЛААД LendMN аппликэйшнээрээ хүссэн үедээ гар утасныхаа ГАНЦХАН ТОВЧ дараад хэрэгцээндээ зориулсан зээлээ авах боломжтой.

Өөрт ойрхон байршлаа асууж зээлийн гэрээ байгуулах бол: 7707-0101

#АймагтааАсуудлааШийд

#ЗонОлондооЗориулья



#ЗонОлондооЗориулья



## Хувьцаагаа эргүүлэн худалдан авах хоёр дахь хөтөлбөр үргэлжилж байна

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 23-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд тус хурлаар компанийн өөрийн гаргасан хувьцааны ханшийг тогтворжуулах зорилгоор хувьцааг үргэлжлүүлэн худалдаж авах шийдвэрийг дахин гаргаж ТУЗ-ийн 21/17 тоот тогтоолоор баталсан билээ.


2021 оны 09 сарын 30-ны өдрийн хаалтын байдлаар 21/17 тоот тогтоолын хүрээнд нийт 11,222,692 ширхэг хувьцаа халаасалсан байна.



## Хувьцааны ханшын мэдээ

“ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлийн амин хөдөлгүүр болох хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс Олон Улсад нийтлэг авч хэрэгжүүлдэг хувьцаагаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулан, хоёр дахь удаагаа хэрэгжүүлж эхэлсэн билээ. Үүний үр дүнд 2021 оны III улиралд компанийн хувьцааны ханшийг тогтворжуулж, хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалсаар байна.

## Хувьцааны ханш




2021.III улиралд:

**13.1 сая ширхэг**

Нийт арилжаалагдсан ширхэг

**597.0 сая төгрөг**

Нийт арилжаалагдсан үнийн дүн



### Хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувь

- Анд Системс ХХК
- Халаасны хувьцаа
- Олон нийт

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж



03

# Харилцагчийн үйлчилгээ



## Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 30 ажилчидтайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2021 оны III улирлын турш нийт 72,747 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 97.37 %-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

Улсын онцгой комиссоос гаргасан хөл хорио дэглэмийг чанд баримтлан үйлчилгээний заал ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, цахим хэлбэрээр болон 09:00- 20:00 цагийн хооронд хуваарийн дагуу харилцагчийн үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэж байна.

**72,747**

III улирлын нийт  
дуудлага

**15 сек**

Хүлээлгийн  
түвшин

**97.37%**

Үйлчилгээ амжилттай  
хүргэсэн

**19,211**

Сошиал сувгаар  
үйлчилсэн



04



# Санхүүгийн үйл ажиллагаа

## Санхүүгийн байдлын хураангуй тайлан

/Аудитлагдаагүй/

2021 оны III улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 37.7 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 30.2 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 5.1 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 16.0 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 21.7 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 10.1 тэрбум төгрөг байна.

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021.I	2021.II	2021.III
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	7.1	1.7	5.1
Зээлийн багц (цэврээр)	27.6	25.7	30.2
Бусад хөрөнгө	3.7	3.7	1.4
Үндсэн хөрөнгө	1.0	0.9	0.8
Биет бус хөрөнгө	0.2	0.2	0.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39.6</b>	<b>32.2</b>	<b>37.7</b>


Өр төлбөр болон эздийн өмч / тэрбум төгрөг/	2021.I	2021.II	2021.III
<b>Өр төлбөр</b>	<b>22.2</b>	<b>14.0</b>	<b>16.0</b>
Эх үүсвэр	19.6	12.5	14.0
Бусад өглөг	2.6	1.5	2.0
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17.4</b>	<b>18.2</b>	<b>21.7</b>
Хувьцаат капитал	9.3	9.1	8.8
Хуримтлагдсан ашиг	8.1	9.1	10.1
Хоёрдогч өглөг	-	-	2.8
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>39.6</b>	<b>32.2</b>	<b>37.7</b>

## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/


2021 оны III улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 10.0 тэрбум төгрөгт хүрч, 2.8 тэрбум төгрөгийн нийт цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021.I	2021.II	2021.III
Нийт орлого	3.0	3.4	3.6
Хүүгийн зардал	(0.9)	(0.8)	(0.6)
<b>Санхүүгийн цэвэр орлого</b>	<b>2.1</b>	<b>2.6</b>	<b>3.0</b>
Банк болон бусад шимтгэл	(0.4)	(0.4)	(0.4)
<b>Шимтгэлийн дараах орлого</b>	<b>1.7</b>	<b>2.2</b>	<b>2.6</b>
Эрсдэлийн сангийн зардал	0.3	0	(0.4)
<b>Эрсдэлийн сангийн дараах орлого</b>	<b>2.0</b>	<b>2.2</b>	<b>2.2</b>
Боловсон хүчний зардал	(0.6)	(0.5)	(0.6)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.5)	(0.5)	(0.5)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>0.9</b>	<b>1.2</b>	<b>1.1</b>
Татварын зардал	(0.1)	(0.2)	(0.1)
<b>Цэвэр ашиг</b>	<b>0.8</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>

Шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг өссөн дүнгээр (тэрбум төгрөг)





05



# Эрсдэлийн удирдлага



## Эрсдэлийн удирдлага

ЛэндМН нь Эрсдэлийн удирдлагын тогтолцоог компанийн үйл ажиллагаа төдийгүй шийдвэр гаргалтад мөрдөн ажиллаж байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн хүндрэл үргэлжилсээр байгаа энэ цаг үед Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан журам, зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Улсын хэмжээнд Ковид-19 халдварын тархалт энэ улиралд улам нэмэгдэж, өдөрт мянга мянгаар шинэ тохиолдол бүртгэгдэж байгаа эрсдэлтэй цаг үед ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс зайнаас, онлайн хэлбэрээр ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Онцгой байдлын үед ажиллах журам” болон “Ковид-19 үеэр ажиллах заавар”-ыг тус тус боловсруулж, батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Энэ нь онцгой эсвэл эрсдэлтэй нөхцөл байдалд компанийн үйл ажиллагаа тасралтгүй найдвартай хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Мөн эрсдэлийн удирдлагын бодлогод суурилж компанийн үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй удирдах, хянах зорилгоор “Үйл ажиллагааны эрсдэлийн журам”-ыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, учирч болзошгүй үйл ажиллагааны эрсдэлүүдийг тодорхойлон бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж ажиллаж байна.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д



заасны дагуу 2021 оны III улиралд 1.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 2.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 124.9%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. Мөн цар тахлаас үүдэлтэй тодорхойгүй нөхцөл байдалд зөв менежментийг хэрэгжүүлэх, урьдчилан таамаглах, хариу арга хэмжээ авах зэрэг нь эрсдэлийн удирдлагын тогтолцоонд шинэ дэвшлийг авчирч, цаашдын компанийн стратегийн хөгжилд нөлөөлөхүйц түлхэц боллоо гэж үзэж байна.

Мөн эдийн засгийн хүндрэлтэй энэ үед төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 32.2%-д барин СЗХ-ны шаардлагыг хангалттай түвшинд хангаж ажиллалаа.

2021 оны III улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс дэлгэрэнгүй харна уу.

### Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021.I	2021.II	2021.III
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46.3%	50.0%	48.8%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	46.3%	50.0%	56.1%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	44.0%	56.6%	50.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас доошгүй	31.7%	12.3%	32.2%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	5.4%	-14.9%	-11.6%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	59.6%	36.8%	36.9%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	36.7%	6.4%	27.5%



06



# Компанийн засаглал



## Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) 2021 оны III улиралд ээлжит 1, ээлжит бус 4 удаа хуралдаж нийт 16 тогтоол гаргалаа. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа, Аудитын хороо 1 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2 удаа хуралдан холбогдох дүгнэлтийг гаргалаа.

Компанийн ТУЗ-өөс баталсан тогтоолуудаас онцлон дурдвал:

- Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийг сонгож, гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олголоо.
- Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулан өөрийн толгой компани болох “АНД Системс” ХХК-аас 2,845,000,000 төгрөгийг хоёрдогч өглөг хэлбэрээр авч, Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.
- “АНД Системс Тех” ХХК-тай 2017 оны 7 сарын 3-ны өдөр байгуулсан “Үйлчилгээний гэрээ” болон “Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрхийн гэрээ”-д тус тус өөрчлөлт оруулахыг зөвшөөрч, шинэчилсэн гэрээний нөхцөлийг батлав. Гэрээг баталгаажуулах, гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олголоо.
- Компанийн Гүйцэтгэх захирал Очирсүрэн овогтой Болдбаатарын өөрийн хүсэлтээр Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, шинэ Гүйцэтгэх захирлаар Бүлтэн овогтой Удвалыг томилов.
- Компанийн ТУЗ-ийн дарга Цэвэгжав овогтой Одмаагийн ТУЗ-ийн даргаас чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээн авч, ТУЗ-ийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн ба Компанийн ТУЗ-ийн даргаар Очирсүрэн овогтой Болдбаатарыг томилов.
- Компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 5-ны өдрийн 21/07 дугаартай “Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
- Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг бүхэлд нь Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-д худалдахаар шийдвэрлэж, “Супер Ап Хэтэвч” ХХК-ийн Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг батлав. Баталсан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцэл байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдахад шаардагдах аливаа хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг гаргах, баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.

- Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Болд овогтой Өлзийбаяр нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 225 тоот “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, мөн 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгсэл бүртгэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтад тус тус заасан шаардлагын дагуу Компанитай аливаа ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх үүднээс ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул компанийн ТУЗ хүсэлтийг хүлээн авч, гишүүний бүрэн эрхийг зогсоов. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөх асуудлыг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр тогтлоо.
- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зохион байгуулж, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос холбогдох дүгнэлтийг гарган ТУЗ-д хүргүүлэв. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, ЗНДЦУ-ын хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдээр Монгол Улсын иргэн Даваасамбуу овогтой Галхүүг томиллоо. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт орууллаа.
- Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Компанийн өрийн бичиг “ЛэндБонд”-ыг нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэж, “ЛэндБонд”-ын хэмжээ, ерөнхий нөхцөлийг батлав. “ЛэндБонд”-ыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан үнэт цаасны зах зээлд оролцогч бусад эрх бүхий этгээдтэй заасан нөхцөлийн хүрээнд холбогдох хэлцэл хийх, гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олгов.
- Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаанд хамтран ажиллах ерөнхий Андеррайтераар “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийг сонгож, тус компанитай байгуулах Андеррайтерийн гэрээний нөхцөлийг батлав.
- Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаанд Андеррайтераар ажиллах “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК нь “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийг өөрийн Синдикатаар сонгож, хамтран ажиллахаар болсон ба үүнтэй холбогдуулан Андеррайтер “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-тай байгуулах Андеррайтерийн гэрээнд Синдикат “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийг оролцуулан гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулах, түүнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захиралд олголоо.
- Компаниас нийтэд санал болгон өрийн бичиг гаргах үйл ажиллагаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийг бүртгэх журам”-д заасан шаардлагын дагуу Компаниас 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланд “Мэжик консалтинг аудит” ХХК-аар хийлгэсэн аудит, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, Компанийн 2021 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэлээ.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоолуудтай Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/> mn) цахим хуудаснаас дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Холбоо барих: “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.МөнхцэцэгУтас: 9901-8886  
имэйл: board@lend.mn



**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)